



**Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд
оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн
мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргасан тухай**

2020.07.30

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5 - д орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хянаж, дүгнэлт гаргуулахаар МАН-ын аймаг, сумын 19 хороо, Ардчилсан намын аймаг, сумын 19 хороо, МАХН-ын аймаг, сумын 19 хороо, Хөдөлмөрийн үндэсний нам, Шударга иргэдийн нэгдсэн эвсэл нам, Иргэний хөдөлгөөний нам зэрэг нийт 96 мөрийн хөтөлбөрийг холбогдох судалгаа, эдийн засгийн тооцооллын хамт хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

Аудитын хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт арга хэмжээ нь:

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа-2050”-д нийцсэн эсэх,
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-т заасан хориглолттой холбоотой асуудлыг тусгасан эсэх,
- Монгол Улсын төсвийн тухай хуульд нийцсэн эсэхийг үнэлж, дүгнэлт гаргалаа.

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцох МАН-ын аймаг, сумын 19 хороо, Ардчилсан намын аймаг, сумын 19 хороо, МАХН-ын аймаг, сумын 19 хороо, Хөдөлмөрийн үндэсний намын 19, Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намын 19, Иргэний хөдөлгөөний намын 1, нийт 96 мөрийн хөтөлбөр нь хуульд заасан шаардлагыг хангасан тул “Нийцсэн” дүгнэлтийг гаргаж, аймаг, сумын сонгуулийн хороо болон намуудад хүргүүлээ.

Хуулийн 37 дугаар зүйлийн 37.6 дахь “..... бие даан нэр дэвшигч нь ээлжит сонгуулийн жилийн 07 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө сонгуулийн мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэж заасан хугацаанд бие даан нэр дэвшигчээс мөрийн хөтөлбөр ирүүлээгүй байна.

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР